


ГҮН УХААН, СОЦИОЛОГИ ХОЁРЫН ХОЛБОО ХАМААРЛЫН ТУХАЙД

*Нацагийн Хавх
Шинжлэх ухааны доктор (ScD), профессор*

1984 онд хэрэглээний социологиор дэд докторын зэрэг хамгаалсан диссертация буддын гүн ухаан дахь арга билгийн сургаалиар арга зүй хийн баяжуулж, 2002 онд "Оюутан залуучуудын нийгмийн харилцааны гүн ухааны агуулга" хэмээх ном болгон хэвлүүлснийг эс тооцвол миний бие сүүлийн хориод жилд социологийн шинжлэх ухаанаас хол хөндий явж ирснийг нуух юун. Тийм болохоор одоо социологийн шинжлэх ухааны хөгжил ямар чиг хандлагатай байгаа, уг ухааны талаар мэргэжлийн хүмүүс ямар ямар үзэл бодол, баримтлалтай байгаа, түүнд шинэчлэлт хэрхэн хийгдсэн, хийгдэж байгаа зэргийн талаар хэлэх юм үгүй шахуу; энэхүү өгүүлэлд шинжлэх ухааны логик буюу шижлэх ухааны философийн үүднээс социологи, гүн ухаан хоёр ямар янзын холбоо хамааралтай байх ёстой, аль алинд нь шинэчлэлт хэрхэн хийгдэх учиртай гэдэг талаар бараг онолын шинжтэй зүйл хөндөн ярихыг зорив.

I. Ертөнц, түүний тухай үнэн мэдлэг хоёр хоёулаа пирамидын бүтэцтэй болох нь

Физикчид "пирамидын хууль"-ийн тухай ярьдаг; энэ нь угтаан ертөнц бүхэлдээ ч, түүний тодорхой хэсэг үзэгдэл, юм ч бүхэлдээн геометрийн пирамидийн дүрсээр илэрхийлэгдсэн зүй тогтолтой, тэрхүү зүй тогтлын хүчээр энэ ертөнц тэр чигээрээ, хаа ч, хэзээ ч дээд зэргийн эмх цэгцтэй, "зорилго зохицтой", гайхалтай нарийн зохион байгуулалттай, уран хийцтэй байх аж.



Зураг №1

Нийгмийн ухаан талаасаа бол зураг №1-ийн I бол ертөнцийн үзэгдэл юмсын хамгийн гүний, хамгийн түгээмэл мөн чанар, хууль, зүй тогтол; тийм зүй тогтлыг европын гүн ухаанд диалектикийн хуулиуд, буддын гүн ухаанд төв үзэл хэмээсээр ирж; II бол нийгмийн гүн ухаан, III бол нийгмийн салбар ухаанууд, IV-тодорхой судалгаа, баримт факт,

Нийгмийн гүн ухааныг анх тэргүүний аугаа их гүн ухаантан Гегель эмхлэн цэгцлэн бүтээсэн гэдэг; тэрээр өөрийн тэр сургаалийг түүхийн гүн ухаан гэж нэрлэж байж. Марксизмд уг сургаалийг түүхийн материализм, О.Конт өөрийн бүтээсэн, түүнтэй хийсвэр сэтгэлгээний түвшний хувьд ойролцоо очих онолоо нийгмийн диалектик, нийгмийн статик, Парсонс бүтэц-үүргийн анализ гэх мэтээр тус тус нэрлэж иржээ.

Нийгэм нь эдийн засаг, улс төр, эрх зүй, боловсрол, хэвлэл мэдээлэл, залуучууд, нийгмийн бүтэц, чөлөөт цаг гэх мэт өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлог, зүй тогтол бүхий бүрэлдэхүүн хэсгүүдтэй байх агаад тэр бүхнийг судалдаг салбар ухаанууд (эдийн засгийн онол, улс төрийн онол гэх мэт), салбар гүн ухаан (эдийн засгийн гүн ухаан, улс төрийн гүн ухаан г.м); салбар социологи (эдийн засгийн социологи, улс төрийн социологи г.м) бий. Эдгээр салбар ухаануудаас зураг 1-ийн III шатны мэдлэг ухаанууд бүрдэнэ. Нийгмийн тухай мэдлэг ийнхүү дараалал, пирамидын


тогтолцоотой байхын цаад үндэс бол нийгэм өөрөө пирамидын бүтэцтэй байна гэсэн үг. Энэ нь юу гэсэн үг вэ гэхлээр аливаа юмс, түүний дотроос нийгмийн үзэгдэл ч төв хүрээний тогтолцоотой байх агаад мөн чанар талаасаа бол нийгэм, соёл иргэншилд л гэхэд түүний хөгжлийн хамгийн гүний зүй тогтол, хууль нь төв болно; учир нь тэрээр дараа дараагийн доод шатныхаа бүтцэд үйлчлэх хууль, зүй тогтлын үндэс суурь нь болно; дараа дараагийн доод шатны бүтэц дэх хууль, зүй тогтол нь хүрээ болно; учир нь тэрээр төвд үйлчлэх ерөнхий хууль, зүй тогтлын агуулгыг баяжуулна; тэдгээрийн эхнийхэд төвөөс татах, түлхэх; хоёр дахид нь төв рүү тэмүүлэх, түүнээс зугтах хүч үйлчилнэ;* үзэгдэл талаасаа бол төр засаг, түүний бодлого, үйл ажиллагаа нь төв; нам, төрийн бус олон нийтийн байгууллага, аж ахуй, боловсрол гэх мэт байгууллагууд, ер нь ард олон бүхэлдээн хүрээ болно гэсэн үг.

Гүн ухаан, нийгмийн гүн ухаан, социологи хэмээх дээрх гурван чигийн мэдлэг өөр хоорондоо пирамидын хуулиар холбогдоно гэж ямар хамааралтай байхын нэр вэ? Пирамид нь тухайн тогтолцоог бүрдүүлэгч элементүүд, бүрэлдэхүүн хэсгүүдийн шүтэн барилдлага буюу синтезлэл, интеграцчиллын ахин дэвших шатлалыг илэрхийлнэ, өөрөөр хэлбэл юмсын хөгжил хөдөлгөөн пирамидын ёроолоос оройд шилжихэд (зураг дээр бол өгсөх сум) пирамидын суурь болох тэгш өнцөгтийн талбайн болон эх бие дэх бүх цэгүүд өөр хоорондоо улам нэгдэн нийлж, нэгний шинж нөгөөдөө шингэн шүтэн барилдаж, синтезлэгдсээр түүний оройн ганц цэг болон хувирна; оройн ганц цэг дээр тэд нэгдэн нийлж, нэгэн бүхэл, урьд өмнөх бүрэлдэхүүн хэсгүүдийн хаана ч байгаагүй цоо шинэ шинж, чанар бий болно; тийм шинж чанарыг европын гүн ухаанд системийн шинж, бүхэл, нэгдэл; буддын гүн ухаанд хоосон чанар хэмээнэ. Тэрхүү цоо шинэ шинж гэдэг нь угтаан аливаагийн хамгийн гүний бөгөөд түгээмэл мөн чанар, зүй тогтол, хууль аж. Энэ бүхнийг гүн ухаан, түүний дотроос сонгодог гүн ухаан судална (зураг №1-ийн I). Ертөнцийн үзэгдэл юм хичнээн ч олон нэр төрөлтэй (зураг №1-ийн II, III) өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлог, зүй тогтолтой байлаа ч, сонгодог гүн ухааныг судалдаг тэрхүү хамгийн гүний, түгээмэл шинжтэй хууль, зүй тогтлын хүрээ хязгаараас хальж гарах гэж үгүй. Тухайн тохиолдол бол нийгмийн гүн ухааны сургаалийн гол агуулга, зарчим (зураг №1-ийн II), сонгодог гүн ухааны (I) хууль, зарчмаас, нийгмийн салбар ухаануудын гол агуулга, зарчим нь (III) нийгмийн гүн ухааны гол агуулга, зарчмын хүрээ хязгаараас хальж гарах учиргүй гэсэн үг. Нийгмийн танин мэдэхүй зураг дээрх өгсөх сумаар салбар ухаанаас нийгмийн гүн ухаанд, түүнээс сонгодог гүн ухаанд ахин дэвшин шилжихийн хэрээр хөгжлийн хамгийн гүний зүй тогтол, мөн чанарт лавшран орно. Энэ нь социологийн хувьд, аль нэгэн асуудлаар явуулах тодорхой шинжилгээний хувьд судалгааны баримт фактыг тухайн салбар социологийн онолоор, шаардлагатай гэж үзвээс тухайн тэр салбарын гүн ухааны онолоор илүү лавшруулах, шаардлагатай хэмэвээс нийгмийн гүн ухааны холбогдох онол сургаалиар, түүнээс илүү ахиулан лавшруулах, шаардлагатай хэмэвээс сонгодог гүн ухааны хууль, зүй тогтлоор тайлбарлаж болно гэсэн үг; тэгвээс уг судалгааны ажлын онолын үнэ цэнэ, түвшин өндөр; судалгааны гарах үр дүн, тайлбарлал зэрэг нь үнэ цэнэ бараг алдахгүй байхын зэрэгцээгээр, шат шатныхаа холбогдох онол сургаалийн агуулгыг арвижуулан баяжуулах нэн чухал ач холбогдолтой болно. Дээрх санааг жишээгээр тодруулваас: ахмад хийгээд залуу үеийнхний үйл ажиллагааны нэг нь нөгөөгөөс хамаарах хамаарлын корреляцийн коэффициент $+0,75$ байснаа $+0,90$ болсон нь тогтоогдсон гэж бодъё. Энэ нь ахмад, залуу хүмүүсийн үйл ажиллагааны шүтэлцээний хир хэмжээ тухайн чиглэлээр нэгэн үе $+0,75$ буюу нилээд өндөр түвшний шууд хамааралтай байснаа дараагийн үед уг хамаарал улам лавширч, $+0,95$ болжээ гэсэн үг. Корреляци лавширсан шалтгааны тайлбарлал нь социологийн онолын түвшинд бол нийгмийн үүрэг (теория социальных ролей) бусад холбогдох холбогдох тусгай онол, парадигмүүдийн агуулгыг нийгмийн гүн ухааны түвшинд бол нийгмийн төрөлх хийгээд үүсгэмэл бүтцийн (теория социального структуры) онолын агуулгыг, сонгодог гүн ухааны түвшинд бол арга билиг, махбодын сургаалийн агуулгыг корреляцийн талаас нь тус тус тодруулж баяжуулна гэсэн үг. Зураг №1-ийн уруудах сумаар илэрхийлэгдэх логикоор онолын илүү өндөр түвшний мэдлэг нь дараа дараагийн мэдлэг, онол сургаалынхаа арга зүй болно; энэ тухай хойно өгүүлэх болно.

* Т"в, хҮрээний тухай Н.Хавх. Оюутан залуучуудын нийгмийн харилцааны гҮн ухааны агуулга. УБ.,2002 номын 30-33 дахь талаас тодруулан харна уу

II. Нийгмийн шинжлэх ухааны хөгжил хийгээд гүн ухаан, социологи хоёр

Ертөнцийн бүх юмс, түүний дотроос шинжлэх ухааны мэдлэг, онол сургаал бүгд улиран дэвших спираль замаар хөгжинө; нэг үе нийгмийн шинжлэх ухаанууд ойртон интеграцчилагдан дэвшиж, түүний дараа цагаа болохоор бие биеэ даасан байдал нь нэмэгдэж, салбарлан хөгжиж, дифференциацлагдана, улирна; түүний дараа эргээд интеграцчилагдана, энэ бүхэн олон удаа дахин давтагдана (зураг 12).



○ -сонгодог хийгээд нийгмийн гүн ухааны зарчим, хууль, категори. Зураг 11-ийн бол I, II.

△ -нийгмийн салбар ухаанууд: эдийн засаг, улс төр, эрх зүй, түүх, угсаатны зүй, сурган, сэтгэл судлал, социологи гэх мэт.

Гүн ухааны онолоор аливаа юмс, түүний дотроос шинжлэх ухааны хөгжил нэгдлээс, нэгдмэл нэгэн мэдлэгийн тогтолцооноос эхээ авна (зураг №2-ын I); зүйрлэвээс эртний Грект философи гэсэн нэрийн дор тэр үеийн шинжлэх ухааны бүх мэдлэг нэгэн бүхэл тогтолцоотой байсан байна; энэ бол тэр үеийн шинжлэх ухааны интеграцийн нэн өндөр түвшин байв; түүний дараа бусад шинжлэх ухаан гүн ухаанаас салж салбарлан биеэ дааж, дифференциацлагдан хөгжинө. (зураг №2-ын II) Энэ үед гүн ухааны зангидлагаа суларч эхэлнэ. Дифференциалт нь оргилдоо хүрч, шинжлэх ухаанууд өөр хоорондоо ямар ч холбоо хамааралгүй болно (зураг №2-ын III), тодорхой шинжлэх ухааны хөгжилд гүн ухаан бараг үүрэггүй шахуу болно. Дифференциацийн шат өндөрлөж, интеграцийн шат буюу тодорхой шинжлэх ухаанууд ойртож, өөр хоорондоо гүн ухаанаар зангидагдаж эхэлнэ (зураг 12-ын IV); тодорхой шинжлэх ухаанууд ойртон ойртсоор сонгодог гүн ухааны арга зүйгээр зангидагдан, дахин интеграцчилагдан шувтарна (зураг №2-ийн V).

Нийгмийн шинжлэх ухааны хөгжил дээрх замаар явж ирсэн, цаашдаа үргэлжлэх зүй тогтолтой аж; гэхдээ эхний нэгдэл, интеграци нь эртний Грекээс бус, Гегелийн түүхийн гүн ухаанаас эхэлсэн аж. Гегель түүхийг шинжлэх ухаан болтлоо дараах 3 шатыг дамжина гээд:

1. хуулбар түүх
 2. гажуудагдсан түүх
 3. гүн ухаанчлагдсан түүх¹⁶ хэмээсэн байдаг. Энэ бол нийгмийн ямар ч ухааны хөгжилд таарч тохирох дараалсан гурван шат.
1. Аль ч шинжлэх ухаан эхлээд эмпирик баримт фактын цуглуулга буюу судлах зүйлийн үзэгдэл талыг хуулбарлан авахаас эхлэнэ; онолоор бол энэ нь эмпирик буюу шинжлэх ухааны баримт факт хуримтлагдах шат болохоос биш шинжлэх ухаан бий болчихсон хэрэг биш.
 2. Шинжлэх ухааны гол зорилго бол баримт факт цуглуулах, үзэгдлийн талыг шинжлэх замаар юмсын дотоод мөн чанарыг тайлбарлах явдал агаад тэрхүү мөн чанарын тухай онол сургаал бий болохгүй байх үед түүнийг судлаач хүн бүр өөр өөрийнхөөрөө, өөр өөсрдийн сонирхолд нийцүүлэн өрөөсгөлөөр тайлбарлана, ойлгоно; элдвийн онол, сургаал маягийн, улмаар бие биеэ үгүйсгэсэн, тэгээд ч бодит байдлыг буруу, дутуу тусгасан тайлбар, үзэл баримтлал бий болгоно; энэ бол нийгмийн гүн ухааны хөгжлийн гажуудагдсан түүхийн шат. Нийгмийн аль ч шинжлэх ухаан шинжлэх ухаан болон болтлоо хөгжлийн энэ шатыг туулна; учир нь тухайн

16 Гегель...

шинжлэх ухааны онол гэв гэнэт бий болчих нь үгүй; элдвийн буруу, зөв тайлбар, үзэл санаа өөр хоорондоо өрсөлдөн тэмцэлдсээр буруу сул нь орхигдож, ололттой, сайн нь өөр хоорондоо нэгдсээр жинхэнэ шинжлэх ухааны тайлбарлал, үзэл онол бий болох жамтай.

3. Нийгмийн аль ч шинжлэх ухаан, социологи ч мөн ялгаагүй юмсын цаад мөн чанарыг зөв бөгөөд харьцангуй бүрэн гүйцэд тайлбарлах онол сургаалтай, тодруулваас өөр өөрийн гэсэн гүн ухаантай болж чадсан цагт сая бие даасан бөгөөд онолын бат суурь дэвсгэртэй, танин мэдэхүйн онолын хийгээд эмпирик түвшинг шүтэн барилдуулж чадсан жинхэнэ шинжлэх ухаан болон хувирна. Энэ бол нийгмийн шинжлэх ухааны хөгжлийн өндөр, дээд гэж хэлж болох түвшин; энэ чигийн шинжлэх ухаан бүхэлдээн, тухайлан авсан аль нэг ухаан нь ч энэ түвшинд байх тохиолдол. Хөгжлийн энэ шатыг Гегель түүхийн гүн ухаан хэмээн нэрлэж, "Түүхийн гүн ухаан" (Философия история. СПб.,1993) хэмээх суут бүтээлээ туурвисан билээ.

Үнэхээр чиг нийгмийн шинжлэх ухааны хөгжил нь гүн ухааны хэлээр бол бага нэгдэл буюу интеграци болох Гегелийн түүхийн гүн ухаанаас эхээ авсан агаад хөгжлийнхөө энэ шатанд нийгмийн тухай тэр үеийн шинжлэх ухааны мэдлэг гүн ухааны сэтгэлгээ, арга зүйгээр нэн сайн зангидагдаж, бараг нэгдмэл нэгэн мэдлэг болж байв. Энэ бүхний биелэл нь Гегелийн түүхийн гүн ухаан байв (зураг №2-ийн I). Хөгжлийн дотоод зүй тогтлоор бол аливаагийн хөгжлийн нэгдэл, интеграцийн шат цагаа болохоор дифференциацийн шатаар солигдож, нэгдэл нь задарч, бүрэлдэхүүн хэсгүүд нь бие даан салбарлан хөгжиж эхэлнэ (зураг №2-ийн II). Энэ үед социологийн гэж нэрлэгдэх болсон газар зүйн, хүн ам зүйн, эдийн засгийн, психологийн, нийгмийн психологийн, биологийн, шилмэл хүмүүсийн гэх мэт нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тус тусад нь авч тайлбарлан, олон тооны онол сургаал бий болж, нийгмийн шинжлэх ухааныг социологийн чиглэлээр цаашид салбарлуулан хөгжүүлж байна. Нийгмийн гүн ухааны хөгжлийн энэ шатанд социологийн дээр өгүүлсэн олон тооны чиглэл, урсгалууд гүн ухаанаар, гүн ухааны сэтгэлгээ, арга зүйгээр ямар нэгэн хэмжээгээр холбогдсон хэвээр байсан болов уу; харин дифференциаци цаашид лаврахын хирээр гүн ухааны үүрэг багасан багассаар, улмаар үүрэггүй болчихсон тийм үе, лав л онолын үүднээс байх агаад тэр нь зураг №2-ын III. Энэ үед европын гүн ухааны ертөнцөд шинжлэх ухаанд гүн ухааны үүрэг гэж байхгүй, гүн ухаан өөрийн судлах зүйлгүй болчихсон, бусад тодорхой шинжлэх ухаанууд уг судлах зүйлийг нь хуваагаад авчихсан, ер нь гүн ухаан бол шинжлэх ухаан биш гэсэн дуалист үзэл бий болсон. Чухам энэ үед социологийн шинжлэх ухааны дифференциаци хэрээс хэтэрч, социологид онол хэрэггүй, судалгааны ажил тэг (0) таамаглалаас эхлэх ёстой хэмээх позитивист үзэл бий болж, социологийн шинжлэх ухаанд эмпиризм дагнах болсон нь хөгжлийн энэ шатных байж. Судалгаагаар хуримтлагдсан баримт факт нь онолын үндэслэл, тайлбаргүй шахуу болж, нийгмийг танин мэдэх үйл ажиллагаа танин мэдэхүйн эмпирик түвшин буюу юмсын өнгөн, гадаад тал, үзэгдлийн хүрэннээс хэтрэхээ больж, мөн чанарын судалгаа угтаан орхигдож, нийгмийн ухаан, түүний дотроос социологийг шинжлэх ухаан гэж хэлэхэд хэцүү болсон үе; нэг үгээр хэлэхэд социологийн ухааны хөгжил мухардалд орсон байна.

Барууны социологийн онолын төлөөлөгч Парсонс болон түүний үеийнхний эрдэмтэд социологийн шинэ онол бий болгох нөр нөсөр эрэл хайгуулд гарсны цаад шалтгаан гэвэл дээр өгүүлсэн мухардлаас гарахыг зорьсных. Ийнхүү социологи, гүн ухааны шүтэн барилдалгын шинэ үе эхэлсэн нь зураг №2-ын IV. Нийгмийн шинжлэх ухаанд интеграцчилал дахин явагдаж, шинжлэх ухаанууд ойртож, гүн ухааны сэтгэлгээ, арга зүйгээр дахин зангидагдаж, аливаа үзэгдэл юмсыг олон талаас нь цогцолбор байдлаар авч үзэх болсон нь энэ аж. Энэ бол нийгмийн шинжлэх ухаан, түүний дотроос социологийн хөгжлийн өнөөгийн шат; одоо үед социологийн дорвитой судалгааг нийгмийн гүн ухааны сонгодог онол (зураг №1-ийн II), салбарын гүн ухаан, (зураг №1-ийн III), улмаар ертөнцийн хөгжлийн түгээмэл зүй тогтлын тухай сонгодог гүн ухаанаар (зураг №1-ийн I) арга зүй хийн явуулах явдал бол шинжлэх ухааны хөгжлөөс дэвшигдэн гарч буй бодит шаардлага.

Социологийн шинжлэх ухаанд, тодруулваас тодорхой судалгааны программ боловсруулах, судалгааны үр дүнг тайлбарлах, социологийн ерөнхий онол, тусгай онол зэргийг бий болгох практик үйл ажиллагаанд гүн ухааныг арга зүй болгон хэрэглэх зам, логик зураг №1-ийн уруудах сумаар явагдана. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр, судалгааны тодорхой баримтыг (зураг №1-ийн IV) авах,

тайлбарлахдаа салбар социологийн холбогдох онол, үзэл зарчимд (үүргийн онол-теория социальной ролей, тогтсон ухамсарын онол-теория установок), тэрхүү тайлбарыг гүнзгийрүүлэхдээ салбарын гүн ухааны зарчимд буюу эрхийн, боловсролын, эдийн засгийн, улс төрийн зэрэг бусад гүн ухааны зарчимд (зураг №1-ийн III); тэрхүү тайлбарыг бүүр гүнзгийрүүлэхдээн нийгмийн гүн ухааны зарчимд (бие хүний онол, нийгмийн харилцааны онол, хүн хийгээд байгаль хоёрын зүй тогтол, нийгмийн бүлгийн онол гэх мэт зураг №1-ийн II); энэхүү тайлбараа нэн гүнзгий лавшруулахдаа сонгодог гүн ухааны зарчимд (зөрчлийн онол, үгүйсгэлийн хууль, хос категоруудын зүй тогтол, арга билиг, махбодын сургаал гэх мэт зураг №1-ийн I) тус тус тулгуурлана. Харин социологийн судалгааны тайлбар нь энэ бүх шатыг заавал тайлбарлах шаардлагагүй бөгөөд аль нэгэн түвшингээр нь хязгаарлаж болно; тухайлбал зураг №1-ийн III-аар социологийн холбогдох онолоор, эсвэл тухайн салбарын гүн ухааны тайлбараар, эсвэл нийгмийн гүн ухааны онолын түвшин дэх холбогдох тайлбараар (зураг №1-ийн II); харин завсрын тайлбарыг орхигдуулан, түүнээс илүү дээд түвшний онолоор шууд тайлбар хийх, уг онолыг хэрэглэх нь тайлбарын агуулгыг ядууруулах, хийсвэр шинжтэй болгох үр дагавартай байж болно. Нийгмийн шинжлэх ухааны интеграцчилагдах үйл явц лавширсаар хэт ирээдүйдээ сонгодог гүн ухааны хууль, зүй тогтол, сэтгэлгээгээр зангидагдсан нийгмийн тухай нэгдмэл нэгэн мэдлэг ухаан болох төлөгчлөл бий (зураг №1-ийн V).

IV. Гүн ухаан, социологи хоёрын шинэчлэлтийн тухайд

А.Эйнштейнээс нь чиг бил үү, нэгэн нэрт физикч, эрдэмтнээс "таныг танихгүй, мэдэхгүй хүн гэж байхгүй юм. Та хэрхэн алдар, нэр хүндийн энэ өндөрлөгт хүрч очсон бэ?" хэмээн асуухад "Энэ өндөрлөгт би өөрөө ч биеэ даагаад оччихсон ч юм биш, харин бусдын мөр дээр гараад зогсчихсон юм" гэж хариулсан гэдэг. Энэ нь урьд өмнөх физикчдийнхээ онол сургаалийг үргэлжлүүлэн, түүн дээр өөрийнхөө хувь нэмрийг оруулсан гэсэн утгатай үг аж. Аливаагийн хөгжил, түүний дотроос аль ч шинжлэх ухааны хөгжил энэ л замаар, хөгжлийн өмнөх шатны түвшинг ахиулах замаар явагддаг байна. Хөгжлийн өмнөх шат нь уламжлал, дараачийн шат нь шинэчлэл аж.

Уламжлалыг хэн нэгэн хүн, хэзээ дуртай цагтаа, санаанаасаа бий болгоогүй, тэрээр хөгжлийн тухайн үеийн эрэлт хэрэгцээ, шаардлагаар түүхэн зайлшгүй зүйл болон үүсч, төлөвшиж, шилдэг сайн, зөв зүйтэй гэдэг нь олон арав, зуу, мянган жилийн туршийн амьдрал практикаар шалгаран, батлагдан нотлогдсон зүйл; шинэчлэлийг ч гэсэн хүмүүс дуртай цагтаа бий болгоод, хүсэлдээ хөтлөгдөн ихэсгэж багасгаж байх зүйл бас биш. Гүн ухааны хэлээр бол уламжлал, шинэчлэл хоёр нэг юмны хоёр тал, хөгжлийн уг сурвалж болох зөрчлийг бий болгогч хоёр тал; тэд харилцан бие биеэ үгүйсгэхийн хэрээр нөхцөлдүүлж байх зүй тогтлоор холбогдоно; буддын гүн ухааны хэлээр бол уламжлал нь тухайн юмны хөгжлийг тогтвортой, тэнцвэртэй, уг юмыг бүрдүүлэгч элементүүдийг өөр хооронд нь шүтэн барилдуулах, хөгжилд залгамж чанарыг бий болгох буюу билиг чигийн үүрэгтэй, шинэчлэл нь дээрхийн яг эсрэг буюу арга талын үүрэгтэй аж.*

Би энэхүү өгүүлэлд гол төлөв манай оронд гүн ухааны шинэчлэлт хэрхэн явагдаж буй; түүний шалтгаан, эцэс сүүлдээ хүрч очих үр дагавар зэргийн тухай товч өгүүлээд, төгсгөлд нь энэ нь социологийн шинжлэх ухааны шинэчлэлд хэрхэн нөлөөлж болох тухай асуудлыг хөндөх болно. Монголчууд бидний гүн ухааны уламжлал гэвэл 1920-1930-аад он хүртэл буддын гүн ухаан, түүнээс хойш 1990 он хүртэл марксист-ленинист гэж нэрлэгдэж ирсэн европын орчин цагийн гүн ухаан. Нийгмийн хөгжлийн тухайн үеийн нөхцөл байдлаас болж энэ хоёр чигийн гүн ухааны аль алийг шинэчлэхээс өөр зам байсангүй.

Европ төвтэй соёл иргэншил ноёрхсон, европын орчин цагийн шинжлэх ухаан, гүн ухаанаар амьсгалан амьдарч буй XX зуунд европын соёлд орохоос, европын шинжлэх ухаанд суралцахаас өөр замгүй; эс тэгвээс хоцрогдсон, сул дорой байдлаасаа хагацаж чадахгүй болчихсон ийм нөхцөл байдалд монголчууд бид уламжлалт гүн ухаанаа шинэчлэхээс өөр гарцгүй болсон байна. Харин тэрхүү уламжлалт "буддын" хэмээх гүн ухааныг шинэчлэхийн оронд "шашин бол хар тамхи" гэсэн үзэл суртлын нэрийн дор түүнийг устгаж, оронд нь европын сонгодог гүн ухааны нэгэн хувилбар

* Энэ тухай Н.Хавх. Монголын нийгмийн гүн ухаан. УБ, 2000 номын 122-129 дэх талаас дэлгэрүүлэн харна уу.

болох марксист гүн ухааныг тэр чигээр нь, байгаа байдлаар нь, механикаар хуулбарлан авсан; зүй нь буддын гүн ухааныг, европын сонгодог гүн ухааны агуулгаар сэлбэн баяжуулж, өргөжүүлэн хөгжүүлэх замаар энэ бүх шинэчлэл явагдах ёстой байж. Энэ бол монгол орон дахь гүн ухааны хүрээнд хийгдсэн анхны устгал байв. Долоон зуу гаруй сүм хийдээ нурааж, ном судрыг нь шатааж, 10,000-аад лам хуврагийнхаа амь насыг хоморголон хөнөөсөн устгал байв. Энэ удаад л лав гүн ухаанчид өмнөх гүн ухаанчдын мөрөн дээр гарч зогсож чадсангүй; энэхүү устгалд гадаадын хүчин зүйлийн үүрэг шийдвэрлэх нөлөөтэй байсан. Марксист онолд нь хэзээд ч үнэ цэнэ нь буурахгүй сонгодог үзэл сургаал бий ч, ялангуяа нийгмийн хөгжлийн талаарх онол нь асуудлыг буруу тавьж шийдвэрлэснээс болж нийгмийн бодит амьдралд таарч тохирохгүй болох нь 1960-1970-аад оноос илэрхий болж, 1990-ээд оны үед уг онолоос ямар нэгэн хэмжээгээр татгалзах, ололттойг нь өвлөн авч, дутагдалтай, сул, бурууг нь үлдэн хөөж, түүнийг бодит байдалд нийцэх, үнэн зөв бусад онол сургаалиар баяжуулан шинэчлэх эл шаардлага хурцаар дэвшигдэн гарч ирсэн хэрэг. Дундад улсын гүн ухаанчид чухамхүү энэ замаар явж гүн ухаанаа ч, улс нийгмээ ч төвшин сайхан авч явж, одоо болоход дэлхийн хөгжлийг тэргүүлсэн хүчирхэг гүрний тоонд орчихоод байна. Хөгжих гэдэг "өмнөх эрдэмтдийнхээ мөрөн дээр гарч зогсоно" гэдгийн амьд жишээ энэ.

Гэтэл манайд 1920-1930-аад оныхоо түүхийг давтав. Марксист философийн хэлбэрээр орж ирсэн өрнийн шинжлэх ухааны сонгодог гүн ухааныг тэр чигээр нь үгүйсгэж, оронд нь барууны, шинжлэх ухааны бус иррационалист, волонтарист, анархист, субъективист эсэн бусын "моодноос гарсан", мөн хараахан гараагүй, гарах цаг нь арай болоогүй зүсэн бүрийн урсгалуудыг гол төлөв гүн ухааны суурь боловсролгүй; боловсролтой гэгдэх боловч сонгодог гүн ухааны агуулгыг жинхэнэ ёсоор нь ухаарч ойлгоогүй, мөн "арван лангийн ембүү хараад алгаа тосдог ээж үү дээ, хорин лангийн ембүү хараад хормойгоо тосдог аав уу даа" гэгчээр улс төр, төгрөг мөнгөний ашиг хонжоо хайгчид бие биеэсээ өрсөлдөн оруулж ирэхийг улайрах болов. Энэ бол монгол дахь гүн ухааны шинжлэх ухаанд гарсан хоёр дахь устгал. 1990-ээд оны эхнээс марксист гүн ухааны ном бүтээлийг овоолж шатаасан, хаягдал цаас авах газарт шилжүүлсэн, марксист гүн ухааны нэр томъёог хэрэглэх, хэлэхийг "амьдын хар нүгэл" хэмээх болсон зэрэг бас бус баримт бий. Гэтэл энэ бүх хувьсгалт үйл явцыг, урьд өмнө марксист философи, үзэл суртлыг хамгаалах үйл хэрэгт амьдралаараа, амь насаараа дэнчин тавьж, зүтгэж; хөрөнгөтний философи, үзэл суртлыг үзэн ядахын дээдээр үзэн ядаж, шүүмжлэхийн дээдээр шүүмжлэн, энэ чиглэлээр олон тооны ном бүтээл туурвиж, энэ үйлсэд амьдрал, амь насаа зориулж байсан зарим нэг хүмүүс манлайлах болсон нь хачирхалтай. Ёстой "уулын бугыг харж унасан морио голов"; "ноёныхоо хатныг үзээд эхнэрээ солив", "шарыг харж шарвав", "улааныг дагаад урвав" гэгч энэ. Европын гүн ухааны хэлээр бол зөрчлийг бий болгогч эсрэг тэсрэг талыг синтезлэх чадваргүйгээсээ болж туйлшрал буюу хоёр хязгаарын хооронд чавхдаж буй нь; буддын гүн ухааны хэлээр бол хоосон чанараар аливааг онож таних, тайлбарлан ухаарах тэнхээгүйгээсээ болж мөнхийн, мөн тасархайн хязгаарт ээлжлэн унаж буй нь энэ. Ган төмрийг ч атугай галд нэг улайсгаж, хүйтэн усанд дүрж хөргөөд энэ бүхнээ дахин давтсаар байваас ган төмөр байтугай төмөр ч биш болдгийн цаана гүн гүнзгий утга агуулга бий. Туйлшрал бүр устгалыг бий болгоно; гүн ухаанд ч мөн адил; шинжлэх ухаан сонгодог гүн ухаанд дээрх маягаар туйлшран хандваас тэр шинжлэх ухаан биш болно; түүнээс гүн ухаан өөрөө шинэчлэл биш байсан, биш болчихоод байгаа хэрэг огт биш аж. Аливаа туйлшралын цаана буддын гүн ухааны хэлээр бол мунхагийн харанхуй хэмээх мэдэхгүй, ойлгохгүйгээс үүдэлтэй бузартсан, нисванис сэтгэл бий. Хэрэв социологийн шинжлэх ухаан дахь шинэчлэл сонгодог гүн ухааныг үгүйсгэх, түүнийг шинжлэх ухаан биш хэмээх үзлийн дор явагдвас хүссэн ч хүсээгүй, "буруу замаар будаа тээвэл буцаад ирэхдээ шороо тээнэ" гэгчээр болно. Өөрөө шинжлэх ухаан биш, социологийн судалгааны баримт фактын цуглуулга, эмпиризм болон хувирна; хэрэв сонгодог гүн ухааны чигийн онолыг шаталсан арга зүй болгох замаар уг шинэчлэлтийг хийвээс "бусдын мөрөн дээр гарч зогсоно" гэдэг болно, социологийн шинжлэх ухааны хөгжил зөв замаар урагшаа итгэл төгс ахин дэвшинэ; хэзээд ч мухардалд үл орно.